

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-11</i>

---

1.Байнгын хорооны даргыг сонгох тухай	4-6
2.Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол /Засгийн газар 2023.11.06-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/	7-11

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 11 дүгээр  
сарын 21-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирцийг танилцуулав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 47 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баттөмөр, Б.Бат-Эрдэнэ, С.Батболд, Д.Ганбат, Ж.Эрдэнэбат;  
Чөлөөтэй: Б.Дэлгэрсайхан;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Сэргэлэн.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд 10 цаг 50 минутаас хуралдааныг даргалж, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулав.

**Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгаланг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаарх саналыг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т заасны дагуу санал хураалт явуулав.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгаланг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 1  
Бүгд: 10  
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан 10 цаг 58 минутаас хуралдааныг даргалав.

**“Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хаалттай горимд шилжүүлэн хэлэлцэв./11:00/**

Хаалттай хуралдаан 17 минут үргэлжилж, 11 цаг 17 минутад нээлттэй горимд шилжүүлэв.

**Хоёр.Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол /Засгийн газар 2023.11.06-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга Г.Манлайжав, мөн албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, Цөмийн технологийн бодлогын газрын дарга М.Чадраабал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Н.Энхболд, Б.Энх-Амгалан нарын тавьсан асуултад Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга Г.Манлайжав хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан үг хэлэв.

**Б.Энх-Амгалан:** Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 5  
Бүгд: 9  
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4

Бүгд: 9  
55.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Энх-Амгалан:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 4  
Бүгд: 9  
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг хэлэлцсэн тухай Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Нээлттэй хуралдаан 18 минут үргэлжилж, 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр 11 цаг 32 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим,  
10 цаг 47 минут

### АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Энх-Амгалан:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Норовын Алтанхуяг ирсэн, Ганибалын Амартүвшин ирсэн, Пүрэв-Очирын Анужин ирсэн, Хавдесламын Баделхан ирсэн Энхтайваны Бат-Амгалан ирсэн Багаагийн Баттөмөр гадаадад томилолттой, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ орон нутгийн томилолттой, Сүхбаатарын Батболд орон нутгийн томилолттой, Дашидондогийн Ганбат гадаадад томилолттой, Нанзадын Наранбаатар ирсэн байна, Салдангийн Одонтуяа ирсэн байна, Дамдины Цогтбаатар ирсэн байна, Нямаагийн Энхболд ирсэн байна, Жаргалтулгын Эрдэнэбат орон нутгийн томилолттой байна.

Гишүүдийн ирц 58.8 хувтай байгаа учир бас ирцийг танилцуулж дууслаа. Хуралдаан эхэлснийг мэдэгдье.

**Н.Энхболд:** Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амрыг эрье. Гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй

байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

Нэгдүгээрт, Байнгын хорооны даргыг сонгох тухай,

Хоёрдугаарт, “Зэвсэгт хүчний зэвсэг техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Энэ тогтоолын төслийг Засгийн газар 2023 оны 10 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн. Байнгын хороогоор хэлэлцэх эсэхийг шийднэ.

Гуравдугаарт, Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт, бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол. Засгийн газар 2023 оны 11 сарын 6-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх асуудал байгаа.

Ийм 3 асуудал байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Өөр саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний асуудлаа хэлэлцье.

**Байнгын хорооны дарга сонгох тухайн асуудлыг хэлэлцэнэ.**

Даргын асуудал хэлэлцэж байгаа учраас хуралдааныг би эхний асуудлыг удирдаад явж байгаа юм.

Байнгын хорооны даргад нэр дэвшигчийн талаар Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс гаргасан

саналыг Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Энхтайваны Бат-Амгалан танилцуулна.

Их Хурлын тухай хуулийн 26.26.4-д Байнгын хорооны даргыг Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршилагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно гэсэн ийм заалттай байгаа юм.

Танилцуулгыг сонсьё.

**Э.Бат-Амгалан:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад Монгол Ардын намын бүлгээс нэр дэвшсэн нэр дэвшигчийн намтрыг та бүхэндээ уншиж танилцуулъя.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан Говь-Алтай аймгийн Алтай хотод төрсөн. Боловсрол- гадаад албаны ажилтан, судлаач. Төгссөн сургууль 1979-1989 онд Говь-Алтай аймгийн 10 жилийн 2 дугаар дунд сургууль, 1989-1991 онд ЗХУ-ын Улсыг аюулаас хамгаалах хорооны академид эрх зүйч мэргэжлээр суралцсан, 1991-1995 онд МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийг гадаад албаны ажилтан судлаач мэргэжлээр төгссөн, 1995-1996 онд Төрийн захиргаа удирдлагын хөгжлийн академид Төрийн удирдлагын менежер, 1997-1998 онд БНХАУ-ын Бээжин хотын гадаад харилцааны их сургууль, Ази Дорно дахины судлал, 2003-2004 онд БНХАУ-ын Хунань мужийн Жан Жа Же хотод аялал жуулчлалын удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх курс, гадаад хэл Орос, Англи, Хятад хэлтэй.

Ажилласан байдал.

1995-1999 онд Монгол Улсын Аюулгүй байдлыг хангах ерөнхий газарт тусгай албаны ажилтан, ахлах ажилтан 1999-2003 онд Ворлд Транс Хязгаарлагдмал хариуцлагатай

компанийн гүйцэтгэх захирал, 2005-2016 онд Мишээл групп Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ерөнхий захирал, 2008-2016 онд НИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч, 2016 оноос одоог хүртэл Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооны гишүүн, 2016 оноос одоог хүртэл Улсын Их Хурал дахь Монгол Оросын парламентын бүлгэмийн дэд дарга, Монгол Хятадын парламентын бүлгэмийн гишүүн, 2019-2020 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын Их Хурал дахь Монгол-Беларус, Монгол-Герман, Монгол-Солонгос, Монгол-Японы парламентын бүлгэмийн гишүүн, 2022 оноос одоог хүртэл Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, 2023 оны 10 дугаар сараас Улсын Их Хурал дахь Монгол Лаосын парламентын бүлгэмийн дарга, 2010 онд Алтан гадас одон, 2011 онд Тусгаар тогтнол одон, 2011 он НИТХ-ын хүндэт тэмдэг, 2014 Нийслэлийн 375 жилийн ойн медаль, 2015 ОХУ-ын Новосибирск хот дахь Оросын ШУА-ийн хүндэт тэмдэг, 2017 он ОХУ-ын Буриадын Бүгд найрамдах улсын хүндэт тэмдэг гэсэн ийм намтартай нэр дэвшигчийг танилцуулж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд, та бүхнийг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Н.Энхболд:** Бат-Амгалан даргад баярлалаа.

Нэр дэвшүүлэгчийн талаар танилцуулга сонслоо. Нэр дэвшигчээс асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Нэр дэвшигчээс асуулт асуух гишүүн байхгүй байна.

Үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье.

Байхгүй байна. Үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулиар 27.1-д Байнгын хорооны даргад Байнгын хорооны гишүүдийн дотроос олонхын саналаар нэр дэвшүүлнэ, нэгдүгээрт ингэж заасан,

Хоёрт, нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн ил сан санал хураалт явуулна.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нэр дэвшигчийг дэмжсэн. Байнгын хорооны даргыг сонгох тухай тухай тогтоол батлагдсанд тооцно. Олонх дэмжээгүй бол өөр хүнийг дэвшүүлж сонгоно. Ийм дэгийн заалттай.

МАН-ын Улсын Их Хурал дахь бүлгээс ирүүлсэн саналыг үндэслээд санал хураалт явуулна.

Бямбасүрэн овогтой Энх-Амгаланг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

10 гишүүн санал хураалтад оролцож, 9 гишүүн дэмжиж, Ардын намын бүлгээс оруулж ирсэн санал дэмжигдэж байна.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Санал дүгнэлтийг Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Бат-Амгалан гишүүн танилцуулчих уу? Манай Байнгын хорооны гишүүн мөн тийм ээ.

Баярлалаа. Нэгдүгээр асуудлаа хэлэлцэж дууслаа.

10.58 цаг

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Энх-Амгалан дарга хурлаа удирдаад явах уу?

**Б.Энх-Амгалан:** Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. Итгэл үзүүлж

улируулан сонгож байгаад их баяртай байна.

10.58 цаг

Ингээд 2 дахь асуудалдаа оръё.

Дараагийн хэлэлцэх асуудал.

Зэвсэгт хүчний зэвсэг техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Энэ тогтоолын төслийн хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурлын гишүүдийн тавьсан асуулт болон төсөл санаачилгын хариулт нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлд батлан хамгаалах зэвсэгт хүчний байлдааны бэлэн байдлыг тодорхойлсон нэгдсэн үзүүлэлт, мэдээлэл, зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, хэрэглэх болон стратегийн төлөвлөлтийн бичиг баримтыг төрийн нууцад хамруулах мэдээлэлд хамаарна гэж заасныг хөндөхөөр байна.

Иймээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3-д хэлэлцэх асуудлын шинж байдал, гишүүдийн саналыг харгалзан асуудлыг хаалттай хуралдаанд хэлэлцэж болно гэж заасны дагуу хуралдааныг хаалттай горимд шилжүүлъя.

Цогтбаатар гишүүн горимын санал гаргая. Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны дарга 1 дүгээрт юуны өмнө дахин сонгогдсонд баяр хүргэе, ажилд нь амжилт хүсье.

Энэ хэлэлцэгдэх асуудал өөрөө улсын нууцад хамрагдах асуудал байгаа учраас энийг нууцын зэрэглэлд хамруулж холбогдох нууцын горимд шилжих горимын саналтай байна.

**Б.Энх-Амгалан:** Цогтбаатар гишүүний гаргасан хуралдааныг хаалттай горимоор хэлэлцье гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт гишүүд.

Санал хураалтад 10 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 70 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Ийм учраас хуралдааныг хаалттай горимд шилжүүлъя.

### НЭЭЛТТЭЙ ХУРАЛДААН ҮРГЭЛЖЛЭВ.

**Б.Энх-Амгалан:** Ажлын хэсгийг урьж оруулъя.

Эхний асуудалтай холбогдуулан ажлын хэсэгт танилцуулсан ажлын хэсгийнхэнд баярлалаа. Амжилт хүсье.

Ажлын хэсгийг урьж оруулъя.

Хуралдаан нээлттэй горимд шилжсэн үү? Нээлттэй горимд шилжсэнээ хэлээрэй.

Дараагийн асуудлаа хэлэлцэж эхэлье.

**Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт болон бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг зөвшилцөх асуудлыг хэлэлцэнэ.**

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд

Сайханбаяр, Д.Баттогтох Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга байна уу? Баттогтох.

2.Б.Батгэрэл Боловсрол, шинжлэх ухааны яамны Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газрын дарга, Б.Жавзанжаргал Боловсрол, шинжлэх ухааны яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга. Танай яамныхан хааччихсан юм бэ? Яагаад ийм чухал асуудал хэлэлцэж байгаа үед ингээд нэрээ өгчхөөд ирдэггүй юм? Боловсрол, шинжлэх ухааны яам.

Цөмийн энергийн комисс. Г.Манлайжав Цөмийн энергийн комиссын Ажлын албаны дарга, Э.Нямдаваа Цөмийн энергийн комиссын ажлын албаны Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга, М.Чадраабал Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Цөмийн технологийн бодлогын газрын дарга.

Ийм хүмүүс оролцож байна. Төслийн талаарх танилцуулгыг Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Сайханбаяр танилцуулна.

Сайханбаяр сайдын микрофоныг өгье.

**Г.Сайханбаяр:** Эрхэм хүндэт Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, гишүүд ээ, Монгол Улс 1972 оноос хойш Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай гэрээ, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц, Цөмийн ослыг шуурхай мэдээлэх тухай конвенц, Цөмийн осол гарсан буюу цацрагийн аюултай байдал бий болсон тохиолдолд тусламж үзүүлэх тухай конвенц, Цөмийн террорист үйлдлийг хориглох тухай олон улсын конвенц зэрэг цөмийн энергийн чиглэлээр олон улсын хэд хэдэн гэрээ конвенцод нэгдэн орсон бөгөөд эдгээр гэрээг конвенцын хүрээнд олон улсын өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж ирлээ.



Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай Улсын Их Хурлын 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 60 дугаар тогтоолд Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд тус тус нэгдэн орох талаар холбогдох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.

Олон улсын атомын энергийн агентлагаас гишүүн орнуудаа эдгээр конвенцод нэгдэн орж дэлхий дахинаа цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй цөмийн терроризм, цөмийн ослоос сэргийлэх, хамгаалах тогтолцоог бэхжүүлэхэд хамтран ажиллахыг уриалсаар байгаа билээ.

Одоогийн байдлаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенцод 91 орон, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенцод 88 орон, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтөд 131 орон, Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд 57 орон нэгдэн орсон байна.

Дээрх конвенцуудад нэгдэн орсноор Монгол Улсын нутаг дэвсгэрт цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах, цацраг идэвхт материалыг аюулгүй тээвэрлэх, цацраг идэвхт эх үүсвэрийн бүрэн бүтэн байдлыг хангах, аюулгүй ажиллагааг сайжруулах, хяналтын тогтолцоог бэхжүүлэх, болзошгүй цөмийн ослоос урьдчилан сэргийлэх олон улсын хамтын

ажиллагаанд идэвхтэй оролцож, олон улсын тавцанд Монгол Улсын байр суурийг бэхжүүлэхээс гадна энэ хүрээнд тусламж авах нөхцөл бололцоог нээж бүрдүүлэх юм.

Тус конвенцууд нь Монгол Улсын Үндсэн хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал холбогдох бусад хууль тогтоомжтой уялдсан бөгөөд төсөвт нэмэлт зардал гарахгүй юм. Иймд дээрх конвенц протоколуудыг соёрхон батлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Сайханбаяр сайдад баярлалаа.

Төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Баделхан гишүүнээр тасаллаа. Би дараа нь нэг асуулт асууна. Баделхан гишүүний микрофоныг өгье.

**Х.Баделхан:** Баярлалаа. Бодлогоо дэмжиж байгаа. Би ганцхан асуулт асуумаар байна л даа. Энэ хэвлэл мэдээллээр байн байн яригдаж байна шүү дээ, энэ цацраг идэвхтийн хаягдлыг Монголд буулилахаар болсон байна гэж ер нь ярьдаг л даа. Энэ яагаад ингээд байн байн яригддаг юм. Энэ дээр ямар нэг тодорхой хариу өгсөн юм уу? Яагаад ингэж яригддаг юм бол? Энэ Монгол Улсад хаягдал буулилахаар болсон байна гэж ярьдаг л даа. Энэ тал дээр нэг тодорхой хариу авчихмаар байна. Иргэддээ ч гэсэн нэг тодорхой хариу өгчихвөл сайн байна. Баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Мааш тодорхой асуулт асуулаа. Хэн хариулах вэ? Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга Манлайжав дарга хариулъя. 3 номерын микрофоныг өгье.

**Г.Манлайжав:** Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Баделхан гишүүний асуулт хариулъя.

Цөмийн хаягдал гэдэг бол цөмийн технологид хэрэглэж байгаа бүх улсуудад үүсдэг, үүсэж байгаа ийм үйл ажиллагаа таны асуулттай холбоотой асуудал бол голлон манай цацраг идэвхт ашигт малтмал ураны уурхайтай, үйл ажиллагаатай холбогдуулж зарим ТББ-ын төлөөллөөс гарсан асуултууд байдаг. Тэгэхээр бол энэ тал дээр бид нар тодорхой тайлбаруудыг өгсөн. Хамгийн сүүлд бид нар энэ оны 6 сард 55 байгууллага тэр дундаа бас мэргэжлийн болон олон нийтийн төрийн бус байгууллагуудыг оруулсан. Цөмийн эсрэг бас үйл ажиллагаа явуулдаг байгууллагын төлөөллүүдийг оролцуулсан олон улсын атомын энергийн агентлагийн Хууль, эрх зүйн газрын энэ цөмийн баталгааны газрын аюулгүй ажиллагааны газрын төлөөллүүдийг оролцсон хэлэлцүүлгийг нээлттэй явуулсан.

Түүн дээр бол мэргэжлийн улсууд Монголын болон олон улсын экспертүүд энэ тал дээр тайлбаруудыг бас нэлээн сайн өгсөн байгаа тэр улсуудад. Тэгэхээр хаягдал бол цөмийн технологи хэрэглэж байгаа үйлдвэр, хөдөө аж ахуй тэр тусмаа хамгийн өргөн хэрэглэж байгаа эрүүл мэндийн салбаруудад хамгийн их үүсдэг. Таны асуудалтай холбоотой тэр нэг хэрвээ бид нар уранаа олборлох юм бол олборлосон шар нунтгаа шар нунтгаар үйлдвэрлэсэн цөмийн түлшийг ашигласных нь дараа Монгол Улс буцааж авах юм байна гэсэн. Ийм логикоор бол манай ТББ-ын нөхдүүд асуудлуудыг тавьсан. Гэтэл бид нар өнөөдөр хэлэлцэж байгаа аюулгүй ажиллагааны конвенцууд дээр энэ заалт асуудал байхгүй.

Хэрвээ цөмийн түлш юм уу хаягдал гэдэг бол өөрийнх нь оронд үүссэн хаана үүсгэсэн цөмийг нь реактор дээр шатаагаад ч юм уу ажиллуулаад гарсан хаягдлыг хэлдэг учраас Монгол Улсад бол хамааралгүй. Тэр тусмаа Шар нунтагтай бол ямар ч хамааралгүй гэдгийг бол энэ хуульд байгаа байгаа,

нөгөө конвенцод байгаа заалтуудаар зааж өгсөн.

Хоёрдугаарт, бид нар бол Монгол Улсын Цөмийн энергийн тухай хууль дээр цацраг идэвхт хаягдлыг буулах гэдэг үйл ажиллагаа нэр томъёо дээр бол зөвхөн өөрийн оронд үүсэж бий болсон цацрагийн хаягдлыг бол бид нар эндээ бол аюулгүй буулах менежментийг зохицуулна гэдгийг бол зааж өгсөн. Энэ дээр нь нөгөө манай Тусгай зөвшөөрлийн тухай хууль дээр энэ бүрэн тодорхой орж өгсөн.

Гуравдугаарт, бид нар Цөмийн энергийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бас бэлдэж өргөн барьж байна. Энэ дээр бас Монгол Улс бол ямар ч гаднын орны цөмийн болон цацраг идэвхт хаягдлыг өөрийн орны нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэхгүй, импортлохгүй, тэр дундаа бол хадгалж буулахгүй гэсэн ийм заалттай байгаа. Баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Баярлалаа. Ингээд Цөмийн аюулгүй ажиллагааны тухай хуулийн 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт болон Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол гэсэн ийм асуудлууд орж ирж байгаа.

Үүний нэгдээгүй нь аль нь вэ? Нэгдсэн нь аль нь вэ? Энэ талаар нэг маш тодорхой мэдээлэл өгөөдхөөч. 3 номерын микрофон.

**Г.Манлайжав:** Энх-Амгалан даргын асуултад хариулъя. Энэ 4 орж ирж байгаа асуудлын 2-т нь, Монгол Улс өмнө нь нэгдэн орчихсон. Энэ Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцод бол Монгол Улс нэгдэн орсон. Энэ 2005 оны нэмэлт бол зөвхөн цөмийн

терроризмтой холбоотой, цөмийн террорист үйл ажиллагаатай холбоотой нэмэлтүүд орж ирж байгаа. Энэ бол Монгол Улс нэгдэн орчихсон байгаа.

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд бид нар нэгдэн орчихсон. Шинэчилсэн нэмэлт дээр бол нэмэлтээр орох гэж байгаа. Монгол Улс нэгдэж ороогүй 2 конвенцоор бол энэ Ашигласан түлшний болон Цацрагт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай конвенц, Цөмийн аюулгүй ажиллагааны конвенц энэ 2-т шинээр Монгол Улс нэгдэн орохоор Байнгын хорооны хуралдаанд оролцож байна.

**Б.Энх-Амгалан:** Нямаагийн Энхболд гишүүний микрофоныг өгье. Нямаагийн Энхболд гишүүн асуултаа асууя. Нямаагийн Энхболд гишүүний микрофоныг.

**Н.Энхболд:** Нэгдэн ороогүй конвенцууддаа тэнд чинь нэмэлт, өөрчлөлт орох гээд байна уу? Тэр конвенцуудад. Анх удаа нэгдэж орох гэж байгаа юм уу? Түүнээс ороогүй конвенцынхоо нэмэлт, өөрчлөлтийн тухай асуудал энд яригдаагүй биз дээ?

**Б.Энх-Амгалан:** Микрофондоо хариулъя. 3 номерын микрофон.

**Н.Энхболд:** Аль алинд нь ороогүй байгаа билээ.

**Б.Энх-Амгалан:** Манлайжав дарга.

**Н.Энхболд:** Тэгээд анх орох гэж байгаа. Тэгээд ороогүй байгаа конвенцын нэмэлт, өөрчлөлтийн тухай асуудал энд яригдаагүй гэдгээ тодорхой хэлж өг.

**Б.Энх-Амгалан:** Энхболд гишүүний асуултад ажлын албаны 3 номерын микрофон, Манлайжав дарга хариулъя.

**Г.Манлайжав:** Энхболд даргын асуултад хариулъя.

Нэгдэж ороогүй 2 конвенц бол тэнд нэмэлт, өөрчлөлтийн асуудал байхгүй. Яг мөрдөгдөж байгаа олон улсад мөрдөж байгаа конвенцууд бид нарын нэгдэж орчихсон 2 конвенцод нэмэлт орсон учраас бид нар энэ дээр нь нэмэлтэд нь нэгдэж орох гэж байгаа юм.

**Б.Энх-Амгалан:** Хариулт авч дууслаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Төсөлтэй холбогдуулан протоколд нэг зүйл тэмдэглүүлье. Энэ хэлэлцээрт бол нэгдэн орохыг дэмжиж байна. Тэгэхдээ энэ хэлэлцээрт нэгдэн орох ийм хэлэлцээр явуулахыг бол Засгийн газарт дэмжсэн ийм асуудал явах байх. Цаашидаа бол Соёрхон батлах тухай хуулийн төсөл орж ирнэ.

Тэгээд та бүгдийн энэ оруулж ирж байгаа материал дээр нэг 2, 3 анхаармаар юм байна шүү. Цөмийн технологийн энхийн хэрэглээнээс үүссэн цацраг идэвхт хаягдал, ураны олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдал, хяналтад буй үйл ажиллагаанаас байгаль орчинд нийлүүлэх хаягдал, ашиглагдахгүй болсон битүү цацраг идэвхт үүсгүүр гэсэн ийм юмнууд байна.

Ийм зүйлүүд нь бол нөгөө манай Монгол Улс гаднын цөмийн хаягдлыг нутаг дээгүүрээ дамжуулахгүй, тээвэрлэхгүй, хадгалахгүй, буулахгүй гэсэн ийм зүйлтэй чинь заавал тохирч байх ёстой шүү. Тэрийгээ хэлэлцээрт орохдоо онцгой анхаараарай. Яагаад гэвэл одоо энэ конвенцыг соёрхон баталсны дараа ард иргэдийн зүгээс болон төрийн бус байгууллагуудын зүгээс хардлага гарна. Монгол Улсад цөмийн

хаягдал буулах гэж байна гэдэг асуудал яригддаг. Тийм учраас бид нар цөмийн хаягдал гаднын улсын цөмийн хаягдлыг буулахгүй юм. Энэ конвенцод нэгдэн орсноор бид нар мэдээллийн эх үүсвэрээ баталгаажуулж байгаа юм. Олон улсад болж байгаа энэ цөмийн хаягдалтай холбоотой асуудлуудын мэдээллүүдийг Монгол Улс авах гэж байгаа юм гэдэг асуудлаа нэлээн сайн тодотгож өгөөрэй гэдгийг сануулъя.

Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулъя.

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт болон Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт гишүүд ээ.

Энэ Бат-Амгалан гишүүний микрофоныг өгье.

**Э.Бат-Амгалан:** Сая би уг нь дэмжиж санал өгсөн юм. Энэ төхөөрөмж болохгүй байна, дахин санал хураалт ч явуулж өгнө үү.

**Б.Энх-Амгалан:** Бат-Амгалан гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Бат-Амгалан гишүүний гаргасан горимын санал 55.6 хувиар дэмжигдлээ.

Түрүүний санал хураалт хүчингүй болсонд тооцлоо. Санал хураалтыг дахин

явуулъя. Томъёоллыг танилцуулсан. Тийм учраас санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд.

Санал хураалт 55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг хэлэлцсэн тухай Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хургүүлнэ. Санал хураалт дууслаа.

11.32 цаг

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ